



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2021 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

**Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон  
Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус  
гишүүнийг сонгон шалгаруулах  
журам батлах тухай**

Монгол Улсын Шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 77 дугаар зүйлийн 77.11, 95 дугаар зүйлийн 95.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ыг нэгдүгээр, “Нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварыг хоёрдугаар, “Ажлын хэсгийн гишүүний баталгаа”-ны загварыг гуравдугаар, “Нэр дэвшигчийн талаарх илтгэгч гишүүний тайлан”-гийн загварыг дөрөвдүгээр, “Монгол Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаарх ажлын хэсгийн тайлан”-гийн загварыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоолыг 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



С.БЯМБАЦОГТ

## **ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН БОЛОН ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ШҮҮГЧ БУС ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ журмын зорилго нь Монгол Улсын Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 77 дугаар зүйлийн 77.11, 95 дугаар зүйлийн 95.7 дахь хэсэгт заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд тавих шаардлагыг хамгийн сайн хангасан иргэнийг сонгон шалгаруулах, томилуулахаар Монгол Улсын Их Хуралд нэр дэвшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүний сонгон шалгаруулалтыг сул орон тоо гарсан тоогоор зарлаж, энэ журмын дагуу нэр дэвшүүлнэ.

1.3.Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулахад дараах зарчмыг баримтална:

- 1.3.1.хууль дээдлэх;
- 1.3.2.шударга ёсыг баримтлах;
- 1.3.3.аливаа нөлөөллөөс ангид, хараат бус байх;
- 1.3.4.төвийг сахих;
- 1.3.5.бодитой хандах;
- 1.3.6.нээлттэй, ил тод байх;
- 1.3.7.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

1.4.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

1.4.1.“шүүгч бус гишүүн” гэж Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг;

1.4.2.“Ерөнхий зөвлөл” гэж Шүүхийн ерөнхий зөвлөлийг;

1.4.3.“Сахилгын хороо” гэж Шүүхийн сахилгын хороог;

1.4.4.“хүсэлт гаргагч” гэж Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргасан иргэнийг;

1.4.5.“нэр дэвшигч” гэж энэ журмын 8.1-д заасны дагуу сонгон шалгаруулалтад нэр дэвшигчээр бүртгэсэн иргэнийг.

1.5.Ерөнхий зөвлөлийн эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүний сонгон шалгаруулалтыг хараат бусаар зохион байгуулах чиг үүрэгтэй Ажлын хэсэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ ажиллана.

1.6.Монгол Улсын Шүүхийн тухай хуульд заасны дагуу Ерөнхий зөвлөлийн болон Сахилгын хорооны шүүгч бус гишүүний сонгон шалгаруулалтыг зохион

байгуулах хугацаа давхацсан бол сонгон шалгаруулалтыг нэг Ажлын хэсэгт хариуцуулахаар Хууль зүйн байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/ шийдвэрлэж болно.

1.7.Ажлын хэсгийн ажиллах нөхцөлийг Байнгын хороо хангах бөгөөд Байнгын хорооны ажлын алба техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ. Энэ журамд заасны дагуу холбогдох баримт бичиг, зар, бусад мэдээллийг цахим хуудаст байршуулах, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгээх, нийтэд мэдээлэхэд Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс, Мэдээллийн технологийн хэлтэс техник, зохион байгуулалт, арга зүйн туслалцаа үзүүлнэ.

1.8.Монгол Улсын Шүүхийн тухай хууль болон энэ журамд зааснаас бусад тохиолдолд Ажлын хэсэг энэ журмын 1.3-т заасан зарчмыг баримтлан ажиллах журам болон хуралдааны дэгээ өөрөө тогтооно.

1.9.Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу өндөржүүлсэн эсхүл бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед Ажлын хэсгийн хуралдааныг цахимаар зохион байгуулах асуудлыг Ажлын хэсэг шийдвэрлэж болно.

1.10.Энэ журмыг баталснаас хойш ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудас [www.parliament.mn/](http://www.parliament.mn/)-д хавсралтуудын хамт байршуулна.

### **Хоёр.Ерөнхий зөвлөлийн болон Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигчид тавих шаардлага**

2.1.Ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь Монгол Улсын Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 76 дугаар зүйлийн 76.3-т заасан дараах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн байна:

- 2.1.1.хууль зүйн өндөр мэргэшилтэй;
- 2.1.2.эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан;
- 2.1.3.төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй;
- 2.1.4.сүүлийн таван жил шүүгчээр ажиллаагүй;
- 2.1.5.сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй;

2.1.6.эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй.

2.2.Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь Монгол Улсын Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 95 дугаар зүйлийн 95.3, 95.4, 95.8-д заасан дараах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн байна:

- 2.2.1.хууль зүйн өндөр мэргэшилтэй;
- 2.2.2.эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан;
- 2.2.3.төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй;
- 2.2.4.сүүлийн таван жил шүүгч, эсхүл улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй;

- 2.2.5.шүүгчээр ажиллаж байгаагүй;
- 2.2.6.Ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллахгүй байгаа;
- 2.2.7.шүүхийн захиргааны ажилтнаар ажиллахгүй байгаа;

- 2.2.8.өмгөөлөгчөөр ажиллахгүй байгаа;
- 2.2.9.прокуророор ажиллахгүй байгаа;
- 2.2.10.эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй.

2.3.Ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь Ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаагүй иргэн байна.

### **Гурав. Сонгон шалгаруулалтын үе шат**

3.1.Сонгон шалгаруулалтыг дараах үе шатаар зохион байгуулна:

- 3.1.1.сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлэх;
- 3.1.2.нэр дэвших тухай хүсэлт гаргах;
- 3.1.3.Ажлын хэсэг байгуулах;
- 3.1.4.нэр дэвшигчээр бүртгэх;
- 3.1.5.нэр дэвшигчийн баримт бичгийг цахим хуудаст байршуулах, асуулт, санал хүлээн авах;
- 3.1.6.нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх;
- 3.1.7.Ажлын хэсгийн ярилцлага зохион байгуулах;
- 3.1.8.нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгох.

### **Дөрөв.Сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлэх**

4.1.Байнгын хороо Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1.2-т заасан хугацаанд Ерөнхий зөвлөлийн эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүртээмжтэй хэлбэрээр давтамжтай мэдээлнэ.

4.2.Энэ журмын 4.1-д заасан зард нэр дэвших тухай хүсэлт гаргах хугацаа, баримт бичиг хүлээн авах хаяг, цахим шуудангийн хаяг, лавлах утасны дугаар, энэ журмын 2.1, 2.2, 2.3-т заасны дагуу Ерөнхий зөвлөлийн эсхүл Сахилгын шүүгч бус гишүүнд тавих шаардлага, энэ журмын 5.1-д заасны дагуу бүрдүүлэх баримт бичгийг заана.

### **Тав.Нэр дэвших тухай хүсэлт гаргах**

5.1.Энэ журмын 4.1-д заасны дагуу зарыг нийтэд мэдээлснээс хойш 21 хоногийн дотор Ерөнхий зөвлөлийн эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд тавих шаардлагыг хангасан иргэн дараах баримт бичгийг Байнгын хороонд хүргүүлэх бөгөөд уг хугацаа дууссанаас хойш баримт бичгийг хүлээн авахгүй:

5.1.1.нэр дэвших тухай хүсэлт, түүний хавсралт /Ерөнхий зөвлөлийн эсхүл Сахилгын хорооны гишүүний хувьд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэлээ бичсэн тайлбар, түүнчлэн мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулгыг хүсэлтэд бичнэ/;

- 5.1.2.төрийн албан хаагчийн анкет;
- 5.1.3.иргэний үнэмлэхийн хуулбар;
- 5.1.4.нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;

5.1.5.эрх зүйн бакалаврын, эсхүл түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;

5.1.6.хууль зүйн өндөр мэргэшилтэй гэдгийг нотлон харуулсан үйл ажиллагааны талаарх баримт;

5.1.7.эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримт;

5.1.8.хүсэлт гаргагчийн талаарх тодорхойлолт;

5.1.9.Шүүхийн тухай хуулийн 76.3 эсхүл 95.3, 95.4, 95.8-д заасан шаардлагыг хангасныг нотлох бусад баримт.

5.2.Энэ журмын 5.1.1-д заасан нэр дэвших тухай хүсэлтийг энэ журмын хоёрдугаар хавсралтаар баталсан загварын дагуу бичиж, холбогдох бүх мэдээллийг үнэн зөв, бүрэн дүүрэн өгнө.

5.3.Энэ журмын 5.1.8-д заасан тодорхойлолтыг гурваас доошгүй хүн /цаашид "тодорхойлогч" гэх/-ээс авч хавсаргана. Тодорхойлогч нь хүсэлт гаргагчийн одоогийн, эсхүл өмнөх ажлын байрны шууд удирдах албан тушаалтан, эсхүл энэ журмын 2.1, 2.2, 2.3-т заасан шаардлага хангасан эсэх тухай бодит мэдээлэл өгөх боломжтой бусад хүн байна.

5.4.Энэ журмын 5.3-т заасан тодорхойлолтод хүсэлт гаргагчийг Ерөнхий зөвлөлийн эсхүл Сахилгын хорооны гишүүнээр ажиллахад тохирсон эсэх, энэ журмын 2.1, 2.2, 2.3-т заасан шаардлагыг хангасан эсэх, түүнтэй ямар хугацаанд ажил хэргийн ямар харилцаатай тухай мэдээллийг бүрэн дүүрэн, үнэн зөвөөр тусгаж, тодорхойлогчийн нэр, эрхэлж байгаа ажил, ажлын газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаягийг бичнэ. Тодорхойлогч нь тодорхойлолтыг бичиж дугтуйнд хийж, гарын үсэг зурж баталгаажуулна.

5.5.Байнгын хорооны ажлын алба нь нэр дэвших тухай хүсэлт, түүний хавсралт, биеийн байцаалтын үнэн зөв байдлыг шалгах зорилгоор хүсэлтэд хавсаргасан баримт бичгийн хуулбарыг эх хувьтай нь тулган үзэж болно.

### **Зургаа.Ажлын хэсэг байгуулах**

6.1.Ажлын хэсэг нь 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

6.2.Энэ журмын 4.1-д заасны дагуу зарыг нийтэд мэдээлснээс хойш 21 хоногийн дотор дараах этгээдээс санал болгосон хүнийг Ажлын хэсгийн гишүүнээр Байнгын хороо томилно:

6.2.1.Монгол Улсын Их Хурлын даргын томилсон Улсын Их Хурлын нэг гишүүн;

6.2.2.Монгол Улсын Их Хурал дахь олонхын бүлгээс санал болгосон нэг төлөөлөл;

6.2.3.Монгол Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн төлөөлөл, хэрэв хэд хэдэн цөөнхийн бүлэг байгаа бол хамгийн олон гишүүнтэй цөөнхийн бүлэг

/цөөнхийн бүлгүүдийн гишүүдийн тоо тэнцүү бол шодож шийдвэрлэнэ/, хэрэв цөөнхийн бүлэг байгуулах гишүүний тоо хүрэлцэхгүй бол цөөнхийн гишүүд хуралдаж олонхоороо санал болгосон нэг төлөөлөл;

6.2.4.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санал болгосон нэг төлөөлөл;

6.2.5.Монгол Улсын Засгийн газраас санал болгосон нэг төлөөлөл;

6.2.6.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын хуралдаанаас санал болгосон нэг төлөөлөл;

6.2.7.Монголын Хуульчдын холбооны Зөвлөлөөс санал болгосон нэг төлөөлөл;

6.2.8.Монголын Өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөлөөс санал болгосон нэг төлөөлөл;

6.2.9.Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс санал болгосон нэг төлөөлөл;

6.2.10.Монголын Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулиас санал болгосон нэг төлөөлөл;

6.2.11.төрийн бус өмчийн хууль зүйн сургуулийн санал болгосон нэг төлөөлөл.

6.3.Энэ журмын 6.2.1-д заасны дагуу томилогдсон Улсын Их Хурлын гишүүн нь Ажлын хэсгийн ахлагч байна. Ажлын хэсгийн ахлагч сонгон шалгаруулалтын бэлтгэлийг хангаж зохион байгуулах, хуралдааныг даргалах бөгөөд энэ журамд өөрөөр заагаагүй бол Ажлын хэсгийн гишүүний эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

6.4.Байнгын хороо энэ журмын 4.1-д заасны дагуу зарыг нийтэд мэдээлснээс хойш ажлын хоёр өдрийн дотор Ажлын хэсгийн гишүүнийг санал болгох тухай мэдэгдлийг энэ журмын 6.2.1-6.2.11-д заасан этгээдэд хүргүүлнэ.

6.5.Энэ журмын 6.2.2-6.2.11-д заасан этгээд нь мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын долоон өдрийн дотор Ерөнхий зөвлөлийн эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах чиг үүргийг гүйцэтгэх мэдлэг, чадвар, туршлага, ёс зүйтэй гэж үзсэн хүний нэрийг Байнгын хороонд ирүүлнэ.

6.6.Энэ журмын 6.5-д заасны дагуу Ажлын хэсгийн гишүүнд санал болгосон төлөөллийг Байнгын хорооны хуралдаанаар нэг бүрчлэн хэлэлцэж тогтоол гаргана. Ажлын хэсгийн гишүүнд санал болгосон хүн нь энэ журмын 6.5-д заасан шаардлагыг хангаагүй гэж үзэн Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналыг аваагүй бол санал болгох эрх бүхий байгууллага ажлын 2 өдрийн дотор өөр хүний нэрийг ажлын хэсэгт оруулахаар Байнгын хороонд ирүүлнэ.

6.7.Энэ журмын 6.3-д заасан тогтоол гарсан даруйд Байнгын хорооны Ажлын алба Ажлын хэсгийн гишүүдэд Ерөнхий зөвлөлийн болон Сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам, бусад бичиг баримтыг хувиалан тарааж, сонгон шалгаруулалтын талаарх танилцуулах сургалт зохион байгуулна.

6.8.Ажлын хэсгийн гишүүн нь Ерөнхий зөвлөлийн эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах явцад энэ журмын 1.3-т заасан зарчмыг баримтална.

### **Долоо.Ажлын хэсгийн бүрэн эрх, хориглох зүйл**

7.1.Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.нэр дэвших тухай хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авах, хянах;

7.1.2.хүсэлт гаргагчийг сонгон шалгаруулалтад нэр дэвшигчээр бүртгэх эсэхийг шийдвэрлэх;

7.1.3.нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх;

7.1.4.нэр дэвшигч холбогдох шаардлагыг хангасан эсэхэд үнэлгээ өгөх;

7.1.5.бүртгэл, сонгон шалгаруулалттай холбоотой гомдлыг эцэслэн шийдвэрлэх;

7.1.6.сонгон шалгаруулалтын үйл явц, дүнг нийтэд мэдээлэх;

7.1.7.сонгон шалгаруулалтын дүнг хуралдаанаараа хэлэлцэж шүүгч бус гишүүнд тавих шаардлагыг хамгийн сайн хангасан гэж үзсэн нэр дэвшигчийг томилуулах саналыг Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4.5-д заасан тоог баримтлан Байнгын хороонд хүргүүлэх;

7.1.8.сонгон шалгаруулалтын материалыг зохих журмын дагуу Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын архивт хүлээлгэн өгөх.

7.2.Ажлын хэсгийн гишүүнд дараах үйл ажиллагааг хориглоно:

7.2.1.нэр дэвшигчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү байх;

7.2.2.Ажлын хэсгийн гишүүний үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн нууцыг задруулах, хувийн зорилгоор ашиглах;

7.2.3.хүсэлт гаргагч, нэр дэвшигчийг ялгаварлан гадуурхах;

7.2.4.сонгон шалгаруулалтад итгэх итгэлийг унагаж зохисгүй байдал гаргах;

7.2.5.Ажлын хэсгийн гишүүний үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан бэлэг, шан харамж авах;

7.2.6.Ажлын хэсгийн гишүүний хувиар нэр дэвшигч нарын талаар урьдчилан дүгнэлт хийж олон нийтэд мэдээлэх;

7.2.7.Ажлын хэсгийн гишүүний нэр хүндийг урвуулан ашиглах.

7.3.Ажлын хэсгийн гишүүнд энэ журмын 7.2.1-д заасан нөхцөл үүссэн бол сонгон шалгаруулах ажиллагаанаас татгалзан гарна.

7.4.Ажлын хэсгийн гишүүн нь хууль болон энэ журамд заасан үүрэг, хориглолтыг биелүүлэх талаар энэ журмын гуравдугаар хавсралтад заасан баталгааг гаргаж Байнгын хороонд хүлээлгэн өгнө.

7.5.Ажлын хэсгийн гишүүн энэ журмын 6.8, 7.2 болон бусад заалтад заасан үүрэг, хориглолтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн нь тогтоогдсон бол Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар огцруулна.

7.6.Ажлын хэсгийн гишүүн хүн энэ журмын 7.5-д заасан зөрчил үйлдсэн нь тогтоогдсон бол Байнгын хорооны хуралдаанд оролцсон олонхын саналаар нээлттэй сануулж нийтэд мэдээлнэ.

7.7.Ажлын хэсгийн хуралдааныг гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, Шүүхийн тухай хууль болон энэ журамд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

### **Найм.Нэр дэвшигчээр бүртгэх**

8.1.Бүртгэл хааснаас хойш ажлын хоёр өдрийн дотор нэр дэвших тухай хүсэлт, холбогдох баримтыг Ажлын хэсэг хуралдаанаар хянан хэлэлцэж сонгон шалгаруулалтад нэр дэвшигчээр бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

8.2.Доор дурдсан тохиолдолд нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзана:

8.2.1.энэ журмын 5.1-д заасан баримт бичгийн бүрдүүлбэрийг хангаагүй;

8.2.2.энэ журмын 5.1-д заасан хугацаанд нэр дэвших тухай хүсэлт гаргаагүй.

8.3.Энэ журмын 8.2-т заасны дагуу нэр дэвшигчээр бүртгээгүй бол энэ тухай хүсэлт гаргагчид бичгээр (шуудан, цахим шуудан, үүрэн холбооны мессэж), эсхүл түүний зөвшөөрснөөр амаар мэдэгдэж тэмдэглэл үйлдэнэ. Хүсэлт гаргагч өөрийг нь нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан үндэслэлийг бичгээр өгөхийг шаардах эрхтэй бөгөөд Ажлын хэсэг энэ тухай тайлбарыг өгнө.

8.4.Хүсэлт гаргагч нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан тухай шийдвэрийг энэ журмын 8.3-т заасны дагуу мэдсэнээс хойш ажлын хоёр өдрийн дотор Ажлын хэсэгт гомдол гаргаж болно.

8.5.Энэ журмын 8.4-т заасны дагуу хүсэлт гаргагч гомдол гаргасан бол Ажлын хэсэг ажлын хоёр өдрийн дотор хуралдаж, гомдлыг эцэслэн шийдвэрлэх бөгөөд энэхүү шийдвэрт гомдол гаргахгүй.

8.6.Энэ журмын 8.2-т заасны дагуу нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсаны улмаас тухайн орон тоонд нэг ч нэр дэвшигч бүртгэгдээгүй бол Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын зарыг дахин явуулах тухай саналыг Байнгын хороонд гаргаж болно.

## **Ес.Нэр дэвшигчийн баримт бичгийг цахим хуудаст байршуулах, асуулт, санал хүлээн авах**

9.1.Энэ журмын 8.1-д заасны дагуу нэр дэвшигчээр бүртгэсэн, эсхүл энэ журмын 8.5-д заасны дагуу гомдлыг эцэслэн шийдвэрлэснээс хойш ажлын нэг өдрийн дотор бүртгэсэн нэр дэвшигчдийн нэрс, нэр дэвших тухай хүсэлт, холбогдох бусад мэдээллийг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж түгээнэ.

9.2.Энэ журмын 9.1-д заасны дагуу байршуулах баримт бичиг, мэдээллээс гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хувь хүний нууцад хамаарах мэдээллийг хасна.

9.3.Энэ журмын 9.1-д заасан баримт бичиг, мэдээллийг байршуулахдаа нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг хүлээн авах хаяг, цахим шуудангийн хаягийг Улсын Их Хурлын цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүртээмжтэй хэлбэрээр давтамжтай мэдээлнэ.

9.4.Энэ журмын 9.1-д заасан баримт бичиг, мэдээллийг байршуулснаас хойш 14 хоногийн дотор нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг Байнгын хорооны Ажлын алба сонирхсон этгээдээс хүлээн авах бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг бүртгэхгүй.

## **Арав.Нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх**

10.1.Энэ журмын 9.1-д заасны дагуу бүртгэсэн шийдвэр гармагц Ажлын хэсэг нэр дэвшигчийг Ажлын хэсгийн ахлагчаас бусад гишүүн бүрд тохиолдлын журмаар тэнцвэртэй хуваарилж илтгэгч гишүүнийг томилно.

10.2.Илтгэгч гишүүн нь дараах ажиллагаа явуулж мэдээлэл бүрдүүлнэ:

10.2.1.энэ журмын 5.1-д заасны дагуу ирүүлсэн хүсэлт, баримт бичгийг судлах, үнэн зөвийг нягтлах;

10.2.2.хэвлүүлсэн бүтээл /ном, өгүүлэл, тайлан зэрэг/ болон олон нийтэд өгсөн мэдээллийг судалж дүгнэх;

10.2.3.энэ журмын 9.4-т заасны дагуу сонирхсон этгээдээс ирүүлсэн асуулт, саналыг судлах;

10.2.4.эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас баримт, мэдээлэл гаргуулан авах;

10.2.5.нэр дэвшигчийн талаар үнэлгээ өгөхөд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл энэ журмын 5.3-д заасан тодорхойлогчтой ярилцлага хийх;

10.2.6.нэр дэвшигч энэ журмын 2.1, 2.2, 2.3-т заасан шаардлагыг хангаж буй эсэхийг тодруулах зорилгоор түүний талаар мэдээлэл өгөх боломжтой арваас доошгүй хүн /нэр дэвшигчийн удирдлага дор нь, түүнийг удирдаж эсхүл хамтран ажиллаж байсан буюу байгаа зэрэг/-тэй ярилцлага хийх;

10.2.7.нэр дэвшигчтэй ярилцлага хийх, түүнээс нэмэлт мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах;

10.2.8.нэр дэвшигчийн талаар үнэлгээ өгөхөд зайлшгүй шаардлагатай мэдээллийг бусад хэлбэрээр цуглуулах.

10.3.Илтгэгч гишүүн энэ журамд заасны дагуу нэр дэвшигч болон бусад этгээдтэй ярилцлага хийхдээ биечлэн, цахим эсхүл бусад хэлбэрийг ашиглаж болох бөгөөд ярилцлагын огноо, цаг хугацаа, гол агуулгын тухай тэмдэглэл үйлдэнэ.

10.4.Илтгэгч гишүүн нэр дэвшигчийн талаар бүрдүүлсэн мэдээлэлд сөрөг агуулга байвал тухайн нэр дэвшигчид танилцуулж тайлбар өгөх боломжоор хангах бөгөөд тухайн мэдээллийг итгэмжлэн өгсөн хүний нэр эсхүл түүнийг таних шинжийн талаар нэр дэвшигчид мэдэгдэхийг хориглоно.

10.5.Байнгын хорооны ажлын албанд нэр дэвшигчийн талаарх мэдээллийг иргэд, олон нийтийн байгууллагаас ирүүлсэн бол илтгэгч гишүүнд тухай бүр танилцуулна.

10.6.Нэр дэвшигч энэ журмын 2.1, 2.2, 2.3-т заасан шаардлагыг хангасан тухай нэмэлт мэдээлэл, баримт бичгийг илтгэгч гишүүнд гаргаж өгч болно.

10.7.Илтгэгч гишүүн нь энэ журмын 10.1-д заасны дагуу хуваарилалт хийгдсэнээс хойш 14 хоногийн дотор нэр дэвшигчийн талаарх мэдээллийг бүрдүүлж, Ерөнхий зөвлөлийн эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд тавих шаардлага тус бүрийг хангасан эсэх талаар үнэлгээ өгсөн, үндэслэл бүхий дэлгэрэнгүй тайланг энэ журмын дөрөвдүгээр хавсралтад заасан загварын дагуу өөрөө бичиж эхний байдлаар бэлтгэнэ.

10.8.Нэр дэвшигчийн талаарх лавлагаа авах, нэмэлт мэдээлэл, баримт, тайлбар гаргуулах зэрэг ажиллагааг Ажлын хэсгийн ахлагч өөрийн санаачилгаар эсхүл итгэгч гишүүний хүсэлтийн дагуу нэгдсэн журмаар зохион байгуулж болно.

### **Арван нэг.Ажлын хэсгийн ярилцлага зохион байгуулах**

11.1.Энэ журмын 10.7-д заасан хугацаа дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор нэр дэвшигч нь холбогдох шаардлагыг хангасан эсэхийг тодруулах зорилгоор Ажлын хэсэг нэр дэвшигч тус бүртэй ярилцлага зохион байгуулна.

11.2.Ажлын хэсэг зургаагаас доошгүй тооны гишүүний ирцтэйгээр ярилцлага хийх бөгөөд Ажлын хэсгийн ахлагч даргална.

11.3.Ярилцлага хийхээс ажлын гурваас доошгүй өдрийн өмнө энэ тухай Улсын Их Хурлын цахим хуудаст байрлуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, нэр дэвшигчид мэдэгдэнэ.

11.4.Нэр дэвшигч ярилцлагад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол бүртгэлээс хасах үндэслэл болно.

11.5.Ажлын хэсгийн гишүүд ярилцлагын үеэр энэ журмын 2.1, 2.2, 2.3-д заасан шаардлагад үндэслэсэн асуултыг оролцогчоос асууж, хариулт авна. Ялгаварлан гадуурхсан эсхүл доромжилсон асуулт асуухыг хориглоно.

11.6.Ажлын хэсгийн ярилцлага хийснээс хойш ажлын дөрвөн өдрийн дотор илтгэгч гишүүн нэр дэвшигчийн талаарх дэлгэрэнгүй тайлан /энэ журмын 10.7-д заасан тайлан/-даа уг ярилцлагын дүн, зайлшгүй шаардлагатай нэмэлт мэдээллийг тусгаж эцэслээд гарын үсэг зурах бөгөөд тайланг цахим хэлбэрээр Ажлын хэсгийн бусад гишүүдэд хүргүүлнэ.

### **Арван хоёр.Нэр дэвшигчийг санал болгох**

12.1.Энэ журмын 11.6-д заасан хугацаа дууссанаас хойш ажлын дөрвөн өдрийн дотор Ажлын хэсэг дараах журмаар хуралдаж Ерөнхий зөвлөлийн эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэх эсэхийг шийдвэрлэнэ:

12.1.1.Ажлын хэсгийн хуралдаанд илтгэгч гишүүн тус бүр өөрт хуваарилагдсан нэр дэвшигчийн талаарх дэлгэрэнгүй тайланг танилцуулах бөгөөд тайлантай холбоотой асуултыг бусад гишүүн асууж болно;

12.1.2.Нэр дэвших тухай хүсэлт, холбогдох баримт бичиг, бүрдүүлсэн мэдээлэл, илтгэгч гишүүний дэлгэрэнгүй тайлан, Ажлын хэсгийн ярилцлагын дүнд үндэслэн нэр дэвшигч энэ журмын 2.1, 2.2, 2.3-т заасан шаардлага тус бүрийг хэрхэн хангаж байгаа талаар Ажлын хэсгийн гишүүн бүр саналаа хэлж зөвлөлдөнө. Ажлын хэсэг нэр дэвшигчийг үнэлэхэд нотолгоогүй мэдээллийг ашиглахгүй;

12.1.3.Ажлын хэсгийн гишүүн тус бүр нэр дэвших тухай хүсэлт, холбогдох баримт бичиг, бүрдүүлсэн мэдээлэл, илтгэгч гишүүний дэлгэрэнгүй тайлан, Ажлын хэсгийн ярилцлагын дүнг үнэлсний үндсэн дээр Ерөнхий зөвлөлийн эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд тавих шаардлагыг хамгийн сайн хангасан гэж дүгнэсэн нэр дэвшигчийн талаар саналаа өгнө.

12.2.Нэр дэвшигчийг тодруулах санал хураалт явуулахдаа дараах журмыг баримтална:

12.2.1.Ажлын хэсгийн гишүүн бүр нэр дэвшигч тус бүрээр дэмжинэ, эсхүл дэмжихгүй санал өгнө;

12.2.2.санал хураалтыг нууцаар явуулна.

12.3.Санал хураалтын дүнгээр Ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг саналын дарааллаар эрэмбэлэн сул орон тоогоор болон дараагийн олонхын санал авсан хоёр хүртэл хүний хамт Улсын Их Хуралд нэр дэвшүүлнэ. Эхний санал хураалтаар тухайн орон тоонд аль ч нэр дэвшигч олонхын санал аваагүй эсхүл санал тэнцсэн бол дахин нэг удаа санал хураалт явуулна.

12.4.Энэ журмын 12.3-т заасны дагуу олонхын санал авсан нэр дэвшигчийн талаарх Ажлын хэсгийн тайланг дараах агуулгаар бэлтгэж /энэ журмын тавдугаар хавсралтаар баталсан загварын дагуу/, хуралдаанд оролцсон Ажлын хэсгийн гишүүд гарын үсэг зурна:

12.4.1.Нэр дэвшигчийн товч танилцуулга;

12.4.2.сонгон шалгаруулалт, түүний үе шат Шүүхийн тухай хууль болон энэ журмын дагуу хэрхэн явагдсан тухай.

12.4.3.нэр дэвшигч нь энэ журмын 2.1, 2.2, 2.3-д заасан шаардлагыг хэрхэн хангаж Ерөнхий зөвлөлийн эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүн болоход хамгийн сайн тохирно гэж үнэлсэн үндэслэл.

12.5.Энэ журмын 12.4-т заасан Ажлын хэсгийн тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хувь хүний нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, таних шинжийг бичихгүй.

12.6.Энэ журмын 12.1-д заасан хуралдаанаас хойш ажлын гурван өдрийн дотор энэ журамд заасны дагуу олонхын санал авсан нэр дэвшигчийн талаарх Ажлын хэсгийн тайлан, холбогдох баримт бичгийг Байнгын хороонд хүргүүлнэ.

12.7.Энэ журмын 12.1, 12.2, 12.3-т заасан санал хураалтаар олонхын санал аваагүй бол тухайн орон тоонд сонгон шалгаруулалт явуулах тухай зарыг нийтэд дахин мэдээлэх саналыг Ажлын хэсэг Байнгын хороонд гаргана.

12.8.Ажлын хэсгийн хуралдаан, түүний тэмдэглэл, илтгэгч гишүүний дэлгэрэнгүй тайлан зэрэг нь албаны нууцад хамаарах бөгөөд холбогдох хууль тогтоомжоор хамгаалагдана.

### **Арван гурав.Улсын Их Хуралд санал болгох**

13.1.Байнгын хороо энэ журмын 12.6-д заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор нэр дэвших тухай хүсэлт /хувь хүний нууцад хамаарах мэдээллийг хасна/ болон Монгол Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаарх Ажлын хэсгийн тайланг Улсын Их Хурлын цахим хуудаст байрлуулж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

13.2.Байнгын хороо энэ журмын 13.1-д заасны дагуу хүсэлт, тайланг байршуулснаас хойш ажлын таван өдрийн дотор томилгооны сонсголын товыг тогтож нийтэд мэдээлнэ.

13.3.Энэ журмын 13.1-д заасан хүсэлт, тайланг байршуулснаас хойш 14 хоногийн дотор нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг сонирхогч этгээд Байнгын хороонд ирүүлэх бөгөөд хаяггүй асуулт, саналыг бүртгэхгүй.

13.4.Энэ журмын 13.3-т заасан хугацаа өнгөрснөөс хойш 14 хоногийн дотор Байнгын хороо томилгооны сонсголыг зохион байгуулна.

13.5.Энэ журмын 13.4-т заасны дагуу томилгооны сонсголыг хийснээс хойш ажлын таван өдрийн дотор Байнгын хороо хуралдаж нэр дэвшигч тус бүрээр хэлэлцэн санал хурааж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг саналын дарааллаар эрэмбэлэн сул орон тооны тоогоор Ерөнхий зөвлөлийн эсхүл Сахилгын хорооны гишүүнээр томилуулах тухай Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

13.6.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд зөвхөн энэ журмын 13.5-д заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг танилцуулах бөгөөд олонхын санал аваагүй нэр дэвшигчийг танилцуулахгүй.

--- оОо ---

## НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

**Товч удирдамж:** Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн дор /ард/ хариултаа үнэн зөв, бүрэн дүүрэн бичнэ. Компьютерын программ ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралтыг Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ. Мөн, нэр дэвших тухай хүсэлтийг Word-ын файлаар цахим шуудан /сонгон шалгаруулах тухай зард заасан хаяг/-аар тус байнгын хороонд явуулна.

### НЭГ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

1.1	<p>Эцэг/эхийн нэр: .....</p> <p>Ургийн овог: .....</p> <p>Нэр: .....</p> <p>Хүйс: .....</p> <p>Төрсөн он: .....</p> <p>Төрсөн газар: .....</p> <p>Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг: .....</p> <p>.....</p> <p>.....</p>
1.2	<p><b>Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал</b> Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүний аль нэгийг бичнэ.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
1.3	<p><b>Иргэний харьяалал</b> Монгол Улсын иргэн мөн үү /тийм эсхүл үгүй гэж бичих/.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
1.4	<p><b>Насны дээр хязгаар</b> Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үү /тийм эсхүл үгүй гэж бичих/.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
1.5	<p><b>Улс төрийн болон намын удирдах албан тушаал</b> Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж</p>

	байгаа эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
	.....
	.....
	.....
1.6	<b>Шүүгчийн албан тушаал</b> Шүүгчээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, аль шүүхэд ямар хугацаанд шүүгчээр ажиллаж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
	.....
	.....
	.....
1.7	<b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн</b> Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
	.....
	.....
	.....
1.8	<b>Шүүхийн сахилгын хорооны гишүүн</b> Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
	.....
	.....
	.....
1.9	<b>Шүүхийн захиргааны байгууллагын ажилтан</b> Шүүхийн захиргааны байгууллагын ажилтны ажил, албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг ажил, албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
	.....
	.....
	.....
1.10	<b>Хуульч</b> Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй юу, эсхүл ийм зөвшөөрөлтэй байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг зөвшөөрлийг ямар хугацаанд эзэмшиж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
	.....

	..... ..... .....
<b>1.11</b>	<b>Өмгөөлөгч</b> Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй юу, эсхүл ийм эрхтэй байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг эрхийг ямар хугацаанд эдэлж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
	..... ..... .....
<b>1.12</b>	<b>Прокурор</b> Прокурорын албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
	..... ..... .....
<b>1.13</b>	<b>Эрүүгийн хариуцлага</b> Эрүүгийн хариуцлага хүлээж байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
	..... ..... .....
<b>1.14</b>	<b>Сахилгын шийтгэл</b> Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан уу /тийм эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.
	..... ..... .....

## ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

<b>2.1</b>	Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны гишүүний хувьд хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /энэ хоёр албан тушаалын аль нэг орон тоог нь сонгож, тайлбарыг 500-1000 үгэнд багтаана/
	..... ..... .....

	<p>.....</p>
--	---

**ГУРАВ. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА**

Д/д	Шалгуур үзүүлэлт
3.1	<p><b>Боловсрол</b>  Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
3.2	<p><b>Эрх зүйч мэргэжлээр ажилласан байдал</b>  Хүсэлт гарагч нь эрх зүйч мэргэжлээр ажилласан ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар тодорхойлон бичих бөгөөд ажил тус бүрийг эрхэлж байсныг нотлох баримтыг хавсаргана. Ажил тус бүрийг тодорхойлохдоо дараах мэдээллийг заавал бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;</li> <li>-ажлын байрны тодорхойлолтын гол агуулга;</li> <li>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;</li> <li>-тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан таваас доошгүй хүний нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/.</li> </ul> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
